



БҮГД НАЙРАМЛАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ГАДААД ЯВЛЛЫН ЯАМНЫ САЙД БҮГД
НАЙРАМЛАХ АРДЧИЛСАН СОЛОНГОС АРД
УЛСАД АЙЛЧИЛСАН ТУХАЙ
АЛБАН МЭДЭЭ

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засаг захиргааны Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч, Гадаад явдлын Яамны сайд нөхөр Хө Дамын үрилгээр Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны гишүүн, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын Яамны сайд Лодонгийн Ринчин БНАСАУ-ын засгийн газрын зочноор Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад 1974 оны 12-р сарын 20-оос 24-ний өдрүүдэд албан ёсны найрсаг айлчлал хийв.

Нөхөр Лодонгийн Ринчин болон түүнийг дагалдагсдыг Солонгосын Хөдөлмөрийн Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын ерөнхийлөгч нөхөр Ким Ир Сен хүлээн авч найрсаг дотноор ярилцав. БНМАУ-ын Гадаад явдлын Яамны сайд нөхөр Лодонгийн Ринчин Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Юмжаагийн Цэдэнбалын илгээлтийг нөхөр Ким Ир Сен-д гардуулав.

БНМАУ-ын Гадаад явдлын Яамны сайд болон түүнийг дагалдагсад Солонгост айлчлах хугацаандаа Пхеньян хотын үйлдвэр, соёл гэгээрлийн газруудыг үзэж, ах дүү солонгосын ард түмний ажил үйлс, амьдрал байдал, социалист бүтээн байгуулалтандаа олсон ололт амжилттай танилцав. Тэнийг очсон газар бүхэнд солонгосын ард түмэн халуун дотноор хүлээн авч байв.

БНМАУ-ын Гадаад явдлын Яамны сайд нөхөр Лодонгийн Ринчин, БНАСАУ-ын Засаг захиргааны Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч, Гадаад явдлын Яамны сайд нөхөр Хө Дам нарны хооронд найрамдал, харилцан ойлгох бадалд хэлэлцээ болов. Хэлэлцээний явцал хоёр тал өөрсдийн орны сайлын талаар харилцан мэдээлж, хоёр улсын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжил хийгээд харилцан сонирхож байгаа зарим асуудлаар санал солилцсон бөгөөд



хэлэлцсэн асуудлаар санал нэг байлаа.

Марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчимд тулгуурласан БНМАУ, БНАСАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны ах дүүгийн харилцаа улс төр, эдийн засаг, соёлын янз бүрийн салбарт хэлбэрэлтгүй хөгжиж, хоёр оронд социализмыг байгуулах үйлсэд тус дөхөм үзүүлдэг байгааг хоёр тал сэтгэл хангалмтай тэмдэглэв. Манай хоёр орон ах дүүгийн харилцааг монгол, солонгосын ард түмний сайн сайхан, энх тайван, социализмын үйл хэргийн төлөө, империализмын эсрэг тэмцлийн эрх ашигт нийгүүлэн хойшид ч хөгжүүлэн өргөжүүлэх хоёр орон, ард түмний зэмэлдэлийг хоёр тал нотлов.

БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойгоо саяхан тэмдэглэсэн ах дүү монголын ард түмний МАХН-ынхаа улирлагын дор социалист бүтээн байгуулалтандаа олсон амжилтанд солонгосын тал баяр хүргэж, Ү таван жилийн төлөвлөгөөгөө биелүүлэхийн төлөө тэмцэлдээ шинэ их амжилт олохыг хүсэн ерөөв.

БНМАУ-ын гадаад харилцаа хэлбэрэлтгүй хөгжиж, олон улсын байр суурь нь өдрөөс өдөрт бэхжиж байгаад баяртай байгаагаа солонгосын тал илэрхийлэв. Ази ба даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг хангах, олон улсын амьдралд болон улс хоорондын харилцаанд тэгш эрх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хундагтах, дотоод хэрэгт үл оролцох, харилцан ашигтай байх зарчмыг хэрэгжүүлэхийн төлөө БНМАУ-ын засгийн газрын хүчин чармайлтыг бүрэн дэмжиж байгаагаа солонгосын тал илэрхийлсэн бөгөөд ийнхүү дэмжиж байгаа явдалд монголын тал гүн талархалаа илэрхийлэв.

Ах дүү солонгосын ард түмэн Солонгосын Хөдөлмөрийн Намын улирлагын дор бие хайргүй хөдөлмөрлөж социализм байгуулах үйлсдээ олсон амжилтанд монголын тал халвун баяр хүргэж, 6 жилийн төлөвлөгөөгөө хугацаанаас нь өмнө биелүүлэхийн төлөө тэмцэлдээ улам их амжилт олохыг хүсэн ерөөв.

Солонгосыг гаднын оролцоогүйгээр биеэ дааж, энх тайван замаар нэгтгэхэд чиглэсэн БНАСАУ-ын засгийн газрын хүчин чармайлт, тухайлбал БНАСАУ-ын ерөнхийлөгч Ким Ир Сений 1973 оны



6-р сард дэвшүүлсэн эх орноо нэгтгэх 5 зүйлт чиг шүтэмжт монголын тал бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлэв. Өмнөд солонгост НҮБ-ын далааны дор байгаа америкийн түрэмгий цэргийг гаргах явдал нь солонгосын хэрэгт гаднын оролцоог зогсоох, солонгосыг энх тайван замаар нэгтгэх урдчилсан нөхцөл мөн гэж монголын тал үзэж, америкийн цэргийг Өмнөд солонгосоос нэн даруй гаргахыг эрс шийдвэртэй шаарлав.

ЕНМАУ-ын засгийн газар солонгосын ард түмний эх орноо нэгтгэх үйл хэргийг тууштай дэмжиж байгаа бөгөөд энэ удаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХХIX чуулган дээр ч солонгосын ард түмний эх орноо нэгтгэх үйл хэргийг дэмжиж идэвхтэй үйл ажиллагаа явуулсан явдалд солонгосын тал гүн талаархал илэрхийлэв.

Олон үлсн асуудлаар санал солилцох явцад социалист орнууд, дэвшилт, энхийг эрхэмлэгч бүх хүчний нэгдэл, нягтралыг бэхжүүлэх, Ази болон даян дэлхийд бат бэх энх тайван, арвүгүй байдлыг хангахын төлөө хойшид ч тууштай тэмцэл явуулах шийдвэр төгс байгаагаа хоёр этгээд нохон тэмцэглэв.

Вьетнамчн талаарх Парисын хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш түүнийг нарийн чанд, хэлбэрэлтгүй биелүүлдэхэд чиглэгдсэн ЕНАВУ-ын засгийн газар, ЕНӨВУ-ын Хувьсгалт Түр засгийн газрын шинэ шатны тэмцэлтэй эв санааны бүрэн нэгдэлтэй байгаагаа хоёр тал илэрхийлэв.

Үлс орноо бүрэн чөлөөлөх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг төлөө явуулж байгаа камбожийн ард түмний шудрага тэмцэл ба үндэсний эвсэл зохиол, үлс орныхоо нэгдлийг хангахын төлөө хийж буй лаосын ард түмний тэмцэлтэй эв санааны бат нэгдэлтэй байгаагаа хоёр тал илэрхийлэв.

Арабын эзлэгдсэн нутгаас израилийн түрэмгийлэгчдийг бүрэн гаргаж Палестинь араб ард түмний үндэсний хууль ёсны эрхийг хангасан үндсэн дээр л Ойрхи дорнодол бат бэх энх тайван тогтох юм гэдэгт итгэл төгс байгаагаа хоёр тал дахин илэрхийлэв.

Чилийн дэвшилт, ардчилсан хүчний эсрэг цэргийн хүчний үйл



даж байгаа ялт үйл ажиллагааг хоёр тал эрс буруушааж, эрх чөлөө, ардчилалын төлөө тэмцэж байгаа чилийн ард түмний тэмцэлтэй эв санааны бүрэн нэгдэлтэй байгаагаа илэрхийлэв.

Эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө, империализм, колончлол, шинэ колончлолын эсрэг Ази, Африк, Латин Америкийн ард түмний тэмцлийг түүвштэй дэмжиж байгаагаа монгол, солонгосын талууд мөдөгдөв.

УНАСАУ-д айлчлах хугацаанд өөрсдийг нь элэгсэг дотноор хүлээн авсан явдалд БНМАУ-ын Гадаад явдлын Яамны сайд УНАСАУ-ын засгийн газар, ард түмэнд чин сэтгэлийн талаархал илэрхийлэв.

БНМАУ-ын Гадаад явдлын Яамны сайдын УНАСАУ-д хийсэн энэхүү айлчлал болон айлчлалын үеэ болсон уулзалт хэлэлцээ, БНМАУ, УНАСАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны харилцааг наашил хөгжүүлэн бэхжүүлэх, социалист орнуудын нэгдэл, нэгтгэлийг зузаатгахад тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэл төгс байгаагаа хоёр тал илэрхийлэв.

Пхеньян хот, 1974 оны 12-р сарын " 24 " .